



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө данснаас хасах, орон нутгийн өмчид бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.2, 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 37,900,000.00 (гучин долоон сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 6,632,499.94 (зургаан сая зургаан зуун гучин хоёр мянга дөрвөн зуун ерэн есөн төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч хавсралтад заасны дагуу Дорнод аймгийн орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Б.Нарантуяа, Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга М.Нямсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах, хүлээлгэн өгөх, орон нутгийн өмч (Халхгол сумын Эрүүл мэндийн төв)-д бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007096

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн  
 ... дугаар тогтоолын хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНСНААС ХАСЧ,  
 ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) 2022.03.31	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Фургон автомашин /Уаз-220695/ ХТТ220695L1212552, улсын дугаар 2965 УБГ	2019/2020	325,000	37,900,000.00	6,632,499.94	31,267,500.06
				<b>37,900,000.00</b>	<b>6,632,499.94</b>	<b>31,267,500.06</b>
	<b>НИЙТ ҮНЭ</b>			(гучин долоон сая есөн зуун мянган төгрөг)	(зургаан сая зургаан зуун гучин хоёр мянга дөрвөн зуун ерэн есөн төгрөг ерэн дөрвөн мөнгө)	(гучин нэгэн сая хоёр зуун жаран долоон мянга таван зуун төгрөг зургаан мөнгө)